



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Онги

“Хүүхэд, гэр бүл хөгжил хамгаалал”-ын
жил болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17 дугаар зүйл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйл, аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалал, аливаа хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн амьдрах, сурч хөгжих, хүмүүжих, ая тухтай орчныг бий болгох зорилгоор 2024 оныг “Хүүхэд, гэр бүл хөгжил хамгаалал”-ын жил болгон зарласугай.
2. “Хүүхэд, гэр бүл хөгжил хамгаалал”-ын жилийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавралтаар баталсугай.
3. “Хүүхэд, гэр бүл хөгжил хамгаалал”-ын жилийн ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг иргэд аж ахуй нэгж, олон нийтэд уриалсугай.
4. “Хүүхэд, гэр бүл хөгжил хамгаалал”-ын жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллахыг сумын Хамтарсан баг болон ажлын хэсгийн гишүүд, ажлын хэсгийн ахлагч нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Г.ЛУВСАНРАГВА



D disk /2024 on/ A Zahiramj.doc

482-01001

D disk /2024 on/ A Tushaal.doc